

Гүйцэтгэх захирлын 2023 оны 03 дүгээр сарын
01- өдрийн 23/1006 тоот тушаалын хавсралт

“СИ И СИ ИНВЕСТМЕНТ ББСБ” ХХК-ЫН

АЖИЛТНЫ ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү ёс зүйн дүрмийн зорилго нь ажилтан Монгол Улсын Үндсэн хууль, “Банкны тухай хууль” болон “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль”, “Си И Си Инвестмент ББСБ” ХХК-н дүрэм, дотоод журмыг сахин биелүүлэх, “Си И Си Инвестмент ББСБ” ХХК-н нэр хүндийг өндөрт өргөж, шударгаар ажиллах, ёс зүйн хэм, хэмжээ, уламжлалт зан үйлийн журмыг тогтоон хэвшүүлэхэд оршино.
- 1.2 “Си И Си Инвестмент ББСБ” ХХК-ны ажилтан бүр энэхүү ёс зүйн дүрмийг сахин биелүүлэх үүрэгтэй.

Хоёр. Компанийн ажилтны ёс зүйн зөрчил

- 2.1 “Си И Си Инвестмент ББСБ” ХХК-ны ажилтны ёс зүйн зөрчил гэж холбогдох хууль болон энэ дүрмээр тогтоосон хэм хэмжээг зөрчсөн санаатай буюу санамсаргүй үйлдэл, эс үйлдлийг хэлнэ.

Гурав. Компанийн ажилтны ёс зүйн хэм хэмжээ

- 3.1 “Си И Си Инвестмент ББСБ” ХХК-ны ажилтан нь Банк бус санхүүгийн байгууллагын ажилтны хувьд үндсэн үйл ажиллагаандаа дагаж мөрдвөл зохих эрх зүйн хэм хэмжээ, зан үйлийн нийлбэр цогцыг компанийн ажилтны ёс зүй гэнэ.
- 3.2 “Си И Си Инвестмент ББСБ” ХХК-ны ажилтан нь албан үүргээ гүйцэтгэхдээ дараах зарчмыг баримтална.
 - 3.2.1 Хуулийг дээдлэн, чанд сахин биелүүлэх,
 - 3.2.2 Компанийн болон харилцагчийн хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэж, хамгаалах,
 - 3.2.3 Шуурхай ажил хэрэгч байх,
 - 3.2.4 Шударга байх,

Дөрөв. Компанийн ажилтанд чиг үүргээ хэрэгжүүлэхэд тавигдах ёс зүйн шаардлага

- 4.1 Компанийн ажилтан нийтээр хүлээн зөвшөөрч, дагаж мөрдөж байгаа ёс зүйн хэм хэмжээг чанд сахина.

- 4.2 Компанийн ажилтан нь Компанийн захиргаатай байгуулсан хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолт, ажилтны баримтлах стандартад заасан шаардлагыг бүрэн хангаж ажиллана.
- 4.3 Компанийн дотоод журмыг чанд сахиж биелүүлнэ.
- 4.4 “Си И Си Инвестмент ББСБ” ХХК-ны нэр хүнд, ажилтны нэр төрийг цэвэр ариун байлгана.
- 4.5 Албан тушаалаа хувийн сонирхолд ашиглах, албаны нэр барих, бусдыг доромжлох, нэр төрийг нь гутаах, сүрдүүлэх, танил тал харах, хүнд суртал, бүдүүлэг зан авир /хамт ажиллагчиддаа саад учруулахгүй байх/ гаргах, ялгаварлан хандах, янз бүрийн арга хэлбэрээр чирэгдүүлэхийг хориглоно.
- 4.6 Компаний ажлын байранд ажлын цагаар албан үүргээ гүйцэтгэх хугацаанд согтууруулах ундаа хэрэглэх, ажилдаа согтуу ирэхийг хориглоно.
- 4.7 Хамтран ажиллагч ажилтнуудынхаа нэр төрийг гутаах, харилцагчдад худал ташаа ойлголт өгөх, ажилд хөндлөнгөөс зүй бусаар оролцох, нөлөөлөхийг хориглоно.
- 4.8 Албан ажил үүрэгтэйгээ холбогдуулан бусдаас хээл хахууль авах, хөнгөлөлттэй нөхцлөөр үйлчлүүлэх, зоог барих, бэлэг сэлт авахыг хориглоно.
- 4.9 Ажил үүргээ гүйцэтгэх явцад өөрт илэрхий болсон байгууллага, хувь хүний нууцыг задруулахыг хориглоно.
- 4.10 Компанийн ажилтан нь үүрэгт ажилдаа хариуцлагатай, мэргэшсэн байхын хамт үнэнч шударга, сахилга дэг журмыг чанд сахиж чаддаг, хувийн зохион байгуулалт сайтай, зан харилцааны дутагдалгүй, төлөвшсөн байна.

Тав. Ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх

- 5.1 Ёс зүйн зөрчлийг дараах үндэслэлээр шалгана.
 - 5.1.1 Иргэд байгууллагаас гаргасан өргөдөл, гомдол, мэдээлэл.
 - 5.1.2 Дотоодын хяналт шалгалтаар.
 - 5.1.3 Шаардлагатай гэж үзвэл Захиргааны санаачлгаар.
 - 5.1.4 Хэвлэл мэдээллий хэрэгслээр мэдээллэсэн.
- 5.2 Ажилтны ёс зүйн зөрчилтэй холбоотой мэдээллийг шалгаж нягталсны үндсэн дээр хянан хэлэлцэж, Гүйцэтгэх захирлын тушаалаар шийдвэрлэнэ.

Зургаа. Ёс зүйн дүрэм зөрчсөн ажилтанд хүлээлгэх хариуцлага

- 6.1 “Си И Си Инвестмент ББСБ” ХХК-ны ажилтны гаргасан зөрчил нь ёс зүйн дүрэмд заасан хэм хэмжээг зөрчиж байгаа бол ажилтан “Хөдөлмөрийн тухай” хууль, Компанийн “Хөдөлмөрийн дотоод журам”, хөдөлмөрийн гэрээнд заасан сахилгын шийтгэл ноогдуулна.
- 6.2 Ёс зүйн зөрчлийн хэм хэмжээ, хор уршиг нь их, компаний дотоод журам, хөдөлмөрийн гэрээнд заасан сахилгын шийтгэл ноогдуулхааргүй бол уг зөрчлийн асуудлыг захиргаа санаачлан хуулийн байгууллагад хүргүүлж, шалгуулна.